

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгагдсан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.3-т “Эдийн засгийг төрөлжүүлэх, аж үйлдвэржүүлэх, бүс нутгуудын хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын оновчтой зохицуулалтыг бий болгох”, 4.2.7-д “... уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.4.2-т “боловсруулах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох” гэж, 2015 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн салбарт баримтлах бодлого”-ын 4.1.1-д “аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх” гэж тус тус тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 3.1.1-д “хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын үйл ажиллагааг уялдуулах, хүнд аж үйлдвэрлэл-худалдаа-хөрөнгө оруулалтын цогц бодлогыг дэмжихэд чиглэсэн Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах” гэж заасан.

Дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар тусгасан боловч өнөөг хүртэл дорвитой ажил хийгдээгүй байна.

2015 онд баталсан “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хуулийг 2020 онд хүчингүй болгосон. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 7.1.7-д ашигт малтмал хайх, газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, боловсруулах үйл ажиллагааг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамруулаагүй. Өөрөөр хэлбэл, хүнд үйлдвэрийн салбар хуулийн зохицуулалтгүй орхигдсон, хүнд үйлдвэрийн салбарт хамрах үйлдвэрлэлийн төрөл, ангилал тодорхойгүй байсан.

Хүнд үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 553.4 мян.тн нүүрсэн шахмал түлш, 9.5 мян.тн катодын зэс, 15.3 мян.тн металл бэлдэц, 16.6 мян.тн металл цувимал, 74.3 тн цахилгааны утас, 9.9 мян.тн кокс тус тус үйлдвэрлэсэн байна. Мөн 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 тэрбум ам.долларын уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг экспортолсноос 2.0 сая ам.долларын кокс, 59.3 сая

ам.долларын катодын зэс экспортолсон нь нийт уул уурхайн гаралтай эрдэс түүхий эдийн экспортын 1.0% орчмыг эзэлж байна.

Экспортын бүтээгдэхүүний 90 орчим хувийг эзэлж буй уул уурхайн бүтээгдэхүүний 95 орчим хувь нь технологийн багтаамжгүй, боловсруулаагүй түүхий эд эзэлж байгаа нь эдийн засгийг хөгжүүлэх ихээхэн боломжийг алдаж байгааг илэрхийлж байна.

Иймээс манай улсын хувьд байгалийн нөөц баялгийн харьцангуй давуу байдалд түшиглэн хүнд үйлдвэрийн томоохон төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт татах, дотоодын зах зээлийг хамгаалах, нэмүү өртөг шингэсэн импортыг орлох, экспортын чиг баримжаатай хүнд үйлдвэрийг хөгжүүлэх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн хуулийн төслийн тандан судалгаанаас харахад тус салбарт нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний экспортын хэмжээ маш бага, үйлдвэрлэлийн технологи хоцрогдсон, төрийн дэмжлэг, зохицуулалт, хяналт хангалтгүй, төрийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалт сул, хүнд үйлдвэр хөгжих боломж, нөхцөл хязгаарлагдмал байгаа нь хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйтэй холбоотой гэж дүгнэсэн.

Дээр дурдсан болон бусад асуудлыг цогцоор шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулав. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгалаа. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолтыг тусгав.

Хоёрдугаар бүлэгт хүнд үйлдвэрийн салбарт хамаарах үйлдвэрлэлийг тодорхойлж, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх зорилго, зарчим, хүнд үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх талаарх зохицуулалтыг тусгав.

Гуравдугаар бүлэгт хүнд үйлдвэрийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулав.

Дөрөвдүгээр бүлэгт хүнд үйлдвэрийн талаар Улсын Их Хурал, Засгийн газар, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргаа болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх болон хүнд үйлдвэр эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлов.

Тавдугаар бүлэгт хүнд үйлдвэрийн талаарх төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбогдох харилцааг зохицуулав.

Зургаадугаар бүлэгт хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заав.

Хуулийн төслийг боловсруулах хүрээнд доор дурдсан арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

-Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны холбогдох газар, хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар, Ашигт малтмал газрын тосны газар, “Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” ТББ, Мэргэжлийн холбоодын төлөөлөл болон салбарын зарим эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажилласан.

-Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасны дагуу Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг Мэргэжлийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлсэн.

-Хуулийн төслийн үзэл баримтлалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан.

-Хуулийн төслийн талаар салбарын мэргэжлийн холбоод, Их дээд сургууль, аж ахуйн нэгжүүд болон төрийн захиргааны төв байгууллагуудаас www.mmhi.gov.mn, www.mrpam.gov.mn цахим хуудсаар санал авсан. Түүнчлэн хуулийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлгийг 2021 оны 3 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулж, саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгасан.

- Хуулийн төслийн тандан судалгааны хүрээнд Аж үйлдвэрийг амжилттай хөгжүүлж байгаа гадаадын 10 гаруй орны сайн туршлагуудаас судалж хуулийн төсөлд тусгасан.

Хүнд үйлдвэрийн тухай хууль батлагдсанаар Монгол улсын нийгэм, эдийн засаг, аж үйлдвэрийн салбарт дараах ахиц дэвшил гарна. Үүнд:

- ✓ Хүнд үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих механизм бүрдэнэ.
- ✓ Хүнд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх дэмжлэгийн хэлбэрүүд тодорхой болно.
- ✓ Шинэ үйлдвэрүүд нэмэгдэж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өснө.
- ✓ Ажлын байр тогтвортой өсөж, хүн амын амьжиргааны түвшин дээшилж, ажилгүйдэл, ядуурал буурна.
- ✓ Хүнд үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барьж байгуулахад төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжих боломж бүрдэнэ.
- ✓ Хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын тээвэр ложистикийн дэд бүтцийг бий болгох нөхцөл бүрдэнэ.

- ✓ Хүнд үйлдвэрт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх ажил эрчимжинэ.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл тус тус боловсруулна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ